



**ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 10 сарын 06 өдөр

Дугаар A/660

Улаанбаатар хот

**Иргэний нисэхийн багц дүрмийн
маягт шинэчлэн батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.2 дахь заалт, 8.4, Иргэний нисэхийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.4.1, 8.4.4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 11.1, 14 дүгээр зүйлийн 14.1, Засгийн газрын 2015 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Дүрэм батлах тухай 258 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэм"-ийн 2.1.5, 2.1.7, 3.5.7, 3.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлогын 2.1.2. дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн "Дүрмийн боловсруулалтын талаар авах арга хэмжээний тухай" А/791 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, нисэхийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор ИНД-12 "Осол, зөрчил болон статистик мэдээлэл"-ийн маягтыг нэгдүгээр хавсралтаар, ИНД-103 "Микролайт агаарын хөлгийн үйл ажиллагаа"-ийн маягтыг хоёрдугаар хавсралтаар, "Иргэний нисэхийн багц дүрмийн бусад маягт"-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2010 оны А/251 дүгээр тушаалын 3, 4 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Орлогч дарга бөгөөд Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын газар /С.Манлай/, Дүрмийн боловсруулалтын хэлтэс /Ё.Энхтөр/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Л.БЯМБАСҮРЭН




Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2016 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн
А/66.0 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



ИНД - 12 "ОСОЛ, ЗӨРЧИЛ БОЛОН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ"-ИЙН МАЯГТ

| Д/д | Дугаар | Нэр | Хуудас тоо | Хуудас дугаар | Өөрчлөлт дугаар |
|---|--------|----------------------------|------------|---------------|-----------------|
| Part 12 Accidents, incidents, and Statistics | | | | | |
| 1 | CA005 | Occurrence Report | 5 | 1-5 | 1 |
| 2 | CA005B | Bird Incident Notification | 1 | 6 | 1 |
| Нийт хуудас | | | 6 | | |


Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн
А/660 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



ИНД - 103 "МИКРОЛАЙТ АГААРЫН ХӨЛГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА"-ИЙН МАЯГТ

| Д/д | Дугаар | Нэр | Хуудас тоо | Хуудас дугаар | Өөрчлөлт дугаар |
|---|----------|---|------------|---------------|-----------------|
| Part 103 Microlight Aircraft – Certification and Operating Rules | | | | | |
| 1 | 24103/01 | Application for issue or Amendment of a Microlight Aircraft Flight Permit | 2 | 7-8 | 1 |
| 2 | 24103/02 | Class 2 Micrlight Survey Form | 2 | 9-10 | 1 |
| Нийт хуудас | | | 4 | | |

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2016 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн
А/660 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРМИЙН БУСАД МАЯГТ

| Д/д | Дугаар | Нэр | Хуудас тоо | Хуудас дугаар | Өөрчлөлт дугаар |
|----------------------|----------|--------------------------------------|------------|---------------|-----------------|
| Miscellaneous | | | | | |
| 1 | 24011/01 | Petition to Raise a Regulatory Issue | 2 | 11-12 | 1 |
| 2 | 24011/02 | Petition for an Exemption | 2 | 13-14 | 1 |
| Нийт хуудас | | | 4 | | |